



НҮҮРСНИЙ ХЭЛТЭС

**ДЭЛХИЙН КОКСЖИХ
НҮҮРСНИЙ
НӨӨЦ БА ЗАХ ЗЭЭЛИЙН
ХЭРЭГЛЭЭ**


2014

Агуулга

- Дэлхийн коксжих нүүрсний нөөцийн тархалтын байдал
- Коксжих нүүрс үйлдвэрлэгч орнууд
- Коксжих нүүрс экспортлогч орнууд
- Коксжих нүүрс импортлогч орнууд
- Коксжих нүүрсний хэрэглэгч зах зээлийн прогноз
- Дэлхийн коксжих нүүрсний зах зээлийн прогноз



Дэлхийн улсуудын нүүрсний батлагдсан нөөц



BP Energy 2012 оны судалгаанаас үзэхэд дэлхийн нүүрсний батлагдсан нөөц 860.94 тэрбум тонн ба одоогийн хэрэглээний түвшингээр тооцвол 112 жилийн нөөцтэй байна. БНХАУ 114.5 тэрбум тонн буюу 13%, Австрали 76.2 тэрбум тонн буюу 9.2%, тус тус эзэлж байна.

Коксжих нүүрс нь ихэвчлэн Ази номхон далай, Хойд Америк, Евроазийн бүс нутагт тархсан байдаг ба ОХУ, БНХАУ, АНУ, Монгол, Австрали, Канад зэрэг орнууд коксжих нүүрсний нөөц ихтэй. Нүүрс үйлдвэрлэл, хэрэглээгээрээ БНХАУ дэлхийд 1-рт ордог.


АНУ-ын нүүрсний нөөц



АНУ нь хамгийн их нүүрсний нөөцтэй орон бөгөөд 2013 оны байдлаар 237.3 тэрбум тонн буюу дэлхийн нүүрсний нөөцийн 27.6%-ийг эзэлж байна. Нүүрс үйлдвэрлэл, хэрэглээгээрээ БНХАУ-ын дараа 2-рт ордог. АНУ-ын нүүрсний давхарга зузаан байдаг тул ил аргаар олборлоход тохиромжтой байдаг ба нийт уурхайн 68% нь ил аргаар, 32% нь далд аргаар олборлолт явуулж байна. Ил уурхайн олборлолтын өртөг харьцангуй бага байдаг.

АНУ-ын коксжих нүүрсний нөөц нийт батлагдсан нөөцийн 35%-г эзэлдэг ба бага дэгдэмхийтэй утаат нүүрсний нөөц харьцангуй бага буюу нийт батлагдсан нөөцийн 1.1%-г эзэлдэг. Коксжих нүүрс олборлодог гол бүс нутаг нь зүүн бүсийн Appalachian.

Австрали улсын нүүрсний нөөц



Австралийн нүүрсний нөөц нь нутгийн зүүн хэсэг буюу Queensland болон New South Wales бүс нутгуудад тархсан байдаг ба улсын батлагдсан нөөцийн 58%, 38%-г тус тус эзэлдэг бол бусад бүс нутгийн нүүрсний нөөц ердөө 4% эзэлдэг. Австралийн сайн чанарын коксжих нүүрс нь Queensland мужийн Bowen басейн, Clarence-Moreton басейн болон New South Wales мужийн баруун хэсэгт тархсан байдаг. Утаат нүүрс нь гол төлөв өмнөд болон баруун бүс нутгуудад тархсан байдаг. Queensland бүс нутгийн уурхайн 85% нь ил аргаар олборлодог бол New South Wales мужийн 73% нь ил аргаар олборлодог. Queensland мужийн коксжих нүүрсний чанар маш сайн, Хятадын Шаньси мужийн нүүрсний чанартай ойролцоо байдаг.



КОКСЖИХ НҮҮРС ҮЙЛДВЭРЛЭГЧ ОРНУУД


The image features a world map with a color-coded legend. The legend includes: a red square for 'COAL PRODUCTION', a blue square for 'COAL CONSUMPTION', and a green square for 'NET EXPORTS'. The map shows significant red areas in North America, Europe, and parts of Asia, indicating major coal production regions. Blue areas are scattered across various continents, representing coal consumption. Green areas are also visible, particularly in parts of South America and Africa, indicating net coal exports. The map is set against a dark blue background.

1986-2012 оны Дэлхийн нүүрс үйлдвэрлэлийн статистик




2003 оны дэлхийн нүүрсний үйлдвэрлэл 5.2 тэрбум тонн байсан бол 2012 онд 7.8 тэрбум тоннд хүрч жилд дундажаар 5% өссөн байна. Өсөлтийн дийлэнх нь Ази Номхон далайн бүс нутгийн БНХАУ, Австрали, Индонез зэрэг орнуудын өсөлт байна.

2008-2013 оны дэлхийн улсуудын коксжих нүүрсний баяжмалын үйлдвэрлэл




Дэлхийн коксжих нүүрсний үйлдвэрлэлийн дийлэнхи хэсгийг БНХАУ, Австрали, ОХУ, АНУ, Канад зэрэг орнууд бүрдүүлж байна. 2008-2013 онд дэлхийн коксжих нүүрсний баяжмалын үйлдвэрлэл 770 сая тонноос 1.1 тэрбум тонн буюу жилд дундажаар 7.3% өссөн байна. Үүнээс БНХАУ 2008 онд 290 сая тонн буюу дэлхийн нийт үйлдвэрлэлийн 38%-г эзлэж байсан бол 2013 онд 580 сая тоннд хүрч 54.9%-г эзлэж, жилд дундажаар 12% өссөн байна.

2010-2013 оны БНХАУ-ын түүхий нүүрсний үйлдвэрлэл




2002-2013 онд Хятад улсын түүхий нүүрсний үйлдвэрлэл 1.4 тэрбум тонноос 4.15 тэрбум тоннд хүрч жилд дунджаар 10.2% өссөн байна. 2002-2013 онд Хятад улсын коксжих түүхий нүүрсний үйлдвэрлэл 0.67 тэрбум тонноос 1.44 тэрбум тоннд хүрч жилд дунджаар 7% өссөн байна. 2013 онд Шаньси мужийн коксжих түүхий нүүрсний үйлдвэрлэл 540 сая тонн буюу улсын нийт үйлдвэрлэлийн 38.5% эзэлж байна. Шаньси, Хэбэй, Шандун, Хэйлунжянь мужийн коксжих нүүрсний үйлдвэрлэл нь улсын нийт үйлдвэрлэлийн 50 гаруй хувийг эзэлж байна.

2012-2018 онд Хятадын коксжих нүүрсний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлт 3%




2013-2018 онд Хятадын нүүрсний зах зээлийн нийлүүлэлт нь эрэлтээс давсан хэвээр байна. Энэ хугацаанд коксжих түүхий нүүрсний үйлдвэрлэл 1.68 тэрбум тоннд хүрч жилд дунджаар 3- 4% өсөлттэй байна. Түүхий нүүрсний нийт өсөлтийн 36% нь коксжих нүүрс байх ба цаашид өсөлтөд эзлэх хувь улам багасах төлөвтэй байна.

2000-2012 оны АНУ-ын нүүрсний үйлдвэрлэл



АНУ-ын нүүрсний үйлдвэрлэл 2000 оноос хойш маш тогтвортой буюу 1 тэрбум тонн орчим байна. Сүүлийн 2 жилд дотоодын нүүрсний хэрэглээ багассан болон байгалийн хийн хэрэглээ нэмэгдсэнээр нүүрсний үйлдвэрлэл багасаж 2013 онд 903 сая тонн буюу өмнөх оноос 19 сая тонноор багассан байна(-2%). EIA (*Эрчим хүчний мэдээллийн төв*)-ийн судалгаагаар ирэх 30 жилийн хугацаанд АНУ-ын нүүрсний үйлдвэрлэл тогтвортой байх ба 2014 онд 3.9% өсөж 939 сая тоннд, 2015 онд 1.5% буурч 924 сая тоннд хүрэх төлөвтэй. 2011 оны байдлаар АНУ-ын нүүрсний үйлдвэрлэлийн хүчин чадал 1.2 тэрбум тонн ба үүнээс ил уурхайн хүчин чадал 812 сая тонн (*ашиглалт 83%*), далд уурхайн хүчин чадал 395 сая тонн (*ашиглалт 78%*) байна.

2008-2013 оны Австралийн коксжих нүүрсний үйлдвэрлэл




2005-2013 онд Австралийн нүүрсний үйлдвэрлэл жилд дунджаар 3.2 хувь өсөж 2013 онд 440 сая тоннд хүрсэн ба үүнээс коксжих нүүрсний үйлдвэрлэл 162 сая тонн байна. Дотоодын нүүрсний хэрэглээ бага, цахилгаан станцуудын нүүрсний хэрэглээ нь нийт хэрэглээний 92%, гангийн үйлдвэрлэл 3%-г эзэлж байна.

BHP Billiton болон Mitsubishi хамтарсан компанийн Queensland муж дахь 8 нүүрсний уурхайн 2013 оны сүүлийн хагаст олборлосон нүүрсний хэмжээ төлөвлөгөөнөөс 22% давж 22 сая тоннд хүрсэн байна. Австралийн нүүрсний олборлолт 2020 онд 550 сая тоннд хүрэх төлөвлөгөөтэй байна.



КОКСЖИХ НҮҮРС ЭКСПОРТЛОГЧ ОРНУУД


2006-2012 онд коксжих нүүрс экспортлогч орнуудын статистик



АНУ-ын коксжих нүүрсний экспорт дэлхийн нийт экспортын 24%-г эзэлдэг ба Австралийн дараа ордог. АНУ-ын коксжих нүүрсний экспортын 50%-г Европт нийлүүлдэг ба энэ нь хамгийн сайн чанарын коксжих нүүрс байдаг. 2015 оноос Европын байгаль орчны хяналтын хууль батлагдаж нүүрсний импортыг их хэмжээгээр багасгах төлөвтэй байгаа. Экспортын 25%-г Азийн орнуудад нийлүүлдэг.

2006-2013 онд АНУ-ын нүүрсний экспорт нэмэгдэж, импорт багассаар 2013 онд 108 сая тонн нүүрс экспортлосон нь өмнөх оноос 4.7% өссөн ба 7.7 сая тонн нүүрс импортлосон нь өмнөх оноос 6.3% буурсан байна. Цэвэр экспорт 100 сая тонн.

2012 оны Канадын нүүрсний экспорт 34 сая тонн



Канад улс жилд 30 гаруй сая тонн коксжих нүүрс экспортлодоогоор АНУ-ын дараа 3-рт ордог. Канадын коксжих нүүрсний экспорт нийт нүүрсний экспортын 85%-89%-г, дэлхийн коксжих нүүрсний экспортын 11%-г эзэлж байна.

2012 онд British Columbia мужийн нүүрсний экспорт 27.3 сая тонн ба үүний 99% нь коксжих нүүрс бол Alberta мужийн нүүрсний экспорт 6.71 сая тонн, үүний 34% нь коксжих нүүрс байна.

2014 оны дэлхийн улсуудын коксжих нүүрсний экспортын прогноз

Сая тонн	2011	2012	2013	2014 f	Өсөлт %
Австрали	133	145	154	160	3.9
Канад	28	31	34	34	0.5
АНУ	63	63	59	57	-4.6
ОХУ	14	18	15	16	5.1
Дэлхий	274	290	309	322	3.1

2014 онд дэлхийн коксжих нүүрсний худалдаа өмнөх оноос 3.2% өсөж 320 сая тоннд хүрэх ба үүнээс Австрали 160 сая тонн, 3.9% өсөх хандлагатай байна.





КОКСЖИХ НҮҮРС ИМПОРТЛОГЧ ОРНУУД

The image features a world map with a dark blue background. Numerous small red dots are scattered across the map, primarily concentrated in North America, Europe, and Asia, representing countries that import coke. The text 'КОКСЖИХ НҮҮРС ИМПОРТЛОГЧ ОРНУУД' is overlaid in the center of the map in a bold, red, serif font.



2004-2013 оны коксжих нүүрс импортлогч орнуудын статистик



Япон улсын нүүрсний импорт




Австрали бол Япон улсын хамгийн том нүүрс экспортлогч юм. Экспортын хэмжээ харьцангуй тогтвортой буюу жилд 100-120 сая тонн нүүрс экспортлож байна. 2004-2012 онд Австрали улсаас импортлосон нийт нүүрсний 58% нь эрчим хүчний нүүрс, 41% нь коксжих нүүрс байсан.

2014 оны дэлхийн коксжих нүүрс импортлогч орнуудын прогноз

	2011	2012	2013	2014 f	Өсөлт, %
Коксжих нүүрсний импорт (сая тонн)					
Европ	46	44	39	42	8.2
Япон	54	52	54	54	1.2
БНХАУ	45	54	75	99	28
Солонгос	32	31	33	32	-2.0
Энэтхэг	34	37	38	38	0.4
Бразил	12	11	13	14	2.5

Австралийн эрчим хүчний газрын мэдээллээр, 2014 онд Европын коксжих нүүрсний импорт 42 сая тонн буюу өмнөх оноос 8%, Япон улс 54 сая тонн буюу өмнөх оноос 1.2%, БНХАУ 99 сая тонн буюу өмнөх оноос 28%, Бразил 14 сая тонн буюу өмнөх оноос 2.5% тус тус өсөх, Энэтхэг улс 38 сая тонн, Солонгос 32 сая тонн буюу өмнөх оноос 2% буурах магадлалтай байна.

2006-2012 оны Дэлхийн коксжих нүүрсний гол хэрэглэгч орнууд



Коксжих нүүрсний баяжмалыг ихэвчлэн гангийн үйлдвэрт хэрэглэдэг бөгөөд хэрэглээ нь жил бүр өссөөр байна. 2007 оны дэлхийн коксжих нүүрсний хэрэглээ 809 сая тонн байсан бол 2012 онд 976 сая тонн болж өссөн байна.

Дэлхийн коксжих нүүрсний баяжмалын дийлэнх хэсгийг Ази тивийн орнууд хэрэглэдэг ба үүнээс БНХАУ хамгийн ихийг хэрэглэж байна. Хятад улсын коксжих нүүрсний баяжмалын хэрэглээ дэлхийн нийт хэрэглээний 49.2%-ийг эзлэж байсан бол 2012 онд 59.35% болж нэмэгдсэн.

Хятад улсын коксын үйлдвэрлэл дэлхийн нийт үйлдвэрлэлийн 60 гаруй хувийг эзэлж байна.

Огноо	Хятадын коксын үйлдвэрлэл (сая тн)	Хятадын коксын экспорт (сая тн)	Коксын экспорт/Коксын үйлдвэрлэл (%)	Дэлхийн коксын үйлдвэрлэлд ялжж хувь (%)	Дэлхийн коксын үйлдвэрлэл (сая тн)	Хятадын кокс экспортын квот (сая тн)	Экспортын унз (ам.доллар/тн FOB)
2000	121.8	15.2	12.48	35.56	342.6	15.0	60.3
2001	131.3	13.9	10.56	38.44	341.6	13.0	66.9
2002	142.8	13.6	9.5	40.68	351.0	13.0	70.6
2003	177.8	14.7	8.28	45.54	390.3	12.0	113.6
2004	208.7	15.0	7.19	49.12	425.0	13.0	263
2005	242.8	12.8	5.26	53.49	453.9	14.0	183.4
2006	297.7	14.5	4.87	57.96	513.6	14.0	138.5
2007	335.0	15.3	4.57	61.48	544.9	12.15	199.6
2008	323.6	12.1	3.75	62.17	520.5	12.0	479
2009	347.9	0.6	0.16	59.8	581.7	11.9	361.3
2010	386.0	3.34	0.87	60	643.3	9.00	392
2011	426.2	3.30	0.77	61.3	695.3	8.42	450
2012	443.2	1.02	0.23	60.8	729.0	9.00	436
2013	476.4	4.67	0.9		754.9	цуцалсан	242



2013 оны дэлхийн коксын үйлдвэрлэл 3.5 орчим хувиар өссөн; 2013 оны Хятадын коксын үйлдвэрлэл 476 сая тн ба өмнөх оноос 7.45% өссөн. 2014 оны дэлхийн коксын үйлдвэрлэлийн өсөлт 3.5 хувиас бага байх төлөвтэй байна.

2013 оны дэлхийн ган үйлдвэрлэлийн хүчин чадал 2 тэрбум тонн ба 450 сая тонны илүүдэлтэй байсан. 2013 оны гангийн бэлдэцийн үйлдвэрлэл 1.6 тэрбум тоннд хүрч өмнөх оноос 3.5% өссөн. Ази, Африк бүс нутгуудын гангийн бэлдэцийн үйлдвэрлэл өсөж байгаа бол Америк, Европ бүс нутгуудын үйлдвэрлэл буурсаар байна.


Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(OECD)-ын судалгаагаар ирэх жилүүдэд гангийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэх хандлагатай, тухайлбал

2013 оны Хятад улсын гангийн үйлдвэрлэл 779 сая тоннд хүрч өмнөх оноос 7.5% өссөн ба дэлхийн нийт үйлдвэрлэлийн тал хувийг эзэлж байна. Хятадын ган үйлдвэрлэгчдийн холбооны тооцооллоор 2014 онд Хятадын гангийн үйлдвэрлэл 3 орчим хувь өсөж 810 сая тонн болно.

Макро эдийн засгийн орчин сайнгүй хэвээр үргэлжлэх төлөвтэй байна. Хятадын засгийн газраас 2014 оны эдийн засгийн өсөлтийг 7.5%-д барих бодлого баримталж байгаа боловч энэ нь гангийн салбарт эерэг үр дүн үзүүлэхэд хүндрэлтэй байна. Үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт хумигдсан, гангийн үйлдвэрлэлийн хэмжээг багасгах, хязгаарлах бодлого хэрэгжүүлж байгаа, гангийн хуримтлал нэмэгдсэн, нийлүүлэлт эрэлтээс давсан зэрэг хүчин зүйлүүд ойрын хугацаанд сайжрах боломжгүй байна.




Олон улсын нүүрсний уурхайн олборлолтын өртөг




Сүүлийн жилүүдэд Австралийн нүүрсний нөөц ашигласны татвар, ажиллах хүчний зардал, тээвэрлэлтийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотойгоор Австралийн нүүрс олборлолтын өртөг нэмэгдсэн. РиоТинто компанийн Queensland мужид байрлах 3 нүүрсний уурхайн олборлолтын өртөг 133 ам.доллар/тонн болсон нь 2005 оноос 343% өссөн байна.

Хятадын коксжих нүүрсний олборлолтын өртөг



Хятадын коксжих нүүрсний үнэ 2013 онд 170-220 юань/тн буурсан ба Шандун мужийн коксжих нүүрс үйлдвэрлэгчид алдагдалд орох хэмжээнд хүрсэн бол Шаньси зэрэг бусад мужийн коксжих нүүрс үйлдвэрлэгчид тодорхой хэмжээнд ашигтай ажиллах боломжтой байна.


Олон улсын коксжих нүүрсний урт хугацааны үнэ



Австралийн коксжих нүүрс нийлүүлэгчид болон Азийн ган үйлдвэрлэгчид 2014 оны 1-р улирлын коксжих нүүрсний үнийг 143 ам.доллар/тн (FOBнөхцөл) тогтоосон нь 2013 оны 4-р улирлаас 9 ам.доллар/тн-оор бага байна. Уг үнэ нь 2010 оны 3-р сараас хойш тогтоосон хамгийн бага үнэ болсон.

Дээрх үнийг Япон, Солонгосын гангийн үйлдвэр болон Австрали, АНУ, Канадын нүүрс үйлдвэрлэгчдийн хооронд байгуулсан урт хугацааны гэрээний үнийг үндэслэн гаргасан ба 2010 оноос эхлэн улирал бүр тогтоодог болсон.

Хятадын коксжих нүүрсний гол бүс нутаг болон боомтуудын нүүрсний үнийн чиг хандлага



2009-2011 онд Хятадын коксжих нүүрсний үнэ огцом өссөн. Шаньси Люлин бүс нутгийн бүрэн коксжих нүүрсний үнэ 2009 оны 1150 юань.тн-оос 2011 онд 1700 юань.тн, Шаньси бүс нутгийн 1/3 коксжих нүүрсний үнэ 2009 оны 950 юань.тн-оос 2011 онд 1550 юань.тн; Австралийн бага дэгдэмхийтэй сайн чанарын коксжих нүүрс Жинтан боомт дээрх үнэ 2009 оны 1250 юань.тн-оос 2011 онд 1750 юань.тн болж тус тус өссөн ба өсөлт 40% хүрч байсан.

2012 оноос өнөөг хүртэл Хятадын коксжих нүүрсний үнэ огцом унаж Шаньси Люлин бүс нутгийн бүрэн коксжих нүүрс 850 юань.тн болж 44% буурсан. 2015-2018 онд Шаньси мужийн коксжих нүүрсний үйлдвэрлэлийн хүчин чадал жил бүр 40-60 сая.тн нэмэгдэж нийлүүлэлтийн илүүдэлтэй хэвээр байна. 2014-2018 онд коксжих нүүрсний үнэ буурсан хэвээр байх ба 2015-2017 онд нүүрсний үнэ 200 юань.тн буух магадлалтай.